



МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА П.ГАНХУЯГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3. Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/301
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Мал эмнэлэг, үржлийн газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт(УСНББОУС)-ын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ



МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Аудитор: Ж.Болормаа
Шинжээч: Б.Баярмаа
Утас: 260512
Цахим хаяг: www.audit.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар

Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/14/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ахлах аудитор Д.Ганбилэг, аудитор Ж.Болормаа, шинжээч Б.Баярмаа нар гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Мал эмнэлэг, үржлийн газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Мал эмнэлэг, үржлийн газар нь дараах хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд,

- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль,
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль,
- Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Шилэн дансны тухай хууль,
- Архивын тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Эмийн талаар төрөөс баримтлах бодлого,
- Төрөөс малчдын талаар бодлого баримтлах тухай 39 тогтоол,
- 2010 оны “Монгол мал” үндэсний хөтөлбөр 23-р тогтоол,
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 47 дугаар тогтоол,
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 71 дүгээр тогтоол зэрэг хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна

Тайлант хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй зарим хуулинд өөрчлөлт орсон байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Мал эмнэлэг, үржлийн газрын үндсэн зорилго нь мал амьтны эрүүл мэндийг хамгаалж, эрүүл малаас ариун цэвэр эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх, малын чанарыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх, удмын санг хамгаалах, цаг үеийн шуурхай мэдээлэл, мэргэжлийн багийн туслалцаагаар салбарын сайдыг хангах явдал юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Мал эмнэлэг, үржлийн газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Мал эмнэлэг, үржлийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын

эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдаас түүвэрлэн аудитын нарийвчилсан горим, сорил 15-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ХХААХҮЯ-ны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 онд шинэчилснийг мөрдөж ажилласан байна. Мал эмнэлэг, үржлийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар боловсруулж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Мал эмнэлэг, үржлийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзэв. /ТАБ-СТА-В-2/

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 1% буюу 322.8 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мал эмнэлэг, үржлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Мал эмнэлэг үржлийн газрын төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 346.6 сая төгрөг, мал эмнэлгийн арга хэмжээний зардалд 30,907.5 сая төгрөг нийт 31,254.1 сая төгрөгийн санхүүжилт авснаас нийт зардалд 31,139.6 сая төгрөг зарцуулж, 114.5 сая төгрөгийг сангийн яаманд татан төвлөрүүлсэн байна.

Үүнээс гадна нэмэлт санхүүжилтийн дансаар Хонины цэцэг өвчний талаар авах арга хэмжээг эрчимжүүлэх ЗГ-ын 95 дугаар тогтоолоор 255 сая төгрөг, ЗГын 256 тогтоолоор 1,137.0 сая төгрөг тус тус батлагдаж, НҮБ-ын ХХАА-н байгууллагаас

төслөөр 74.8 сая төгрөгийн хандивын санхүүжилт авч гүйцэтгэлээр нийт 1,207.5 сая төгрөгийг зарцуулсан байна

НҮБ-ын ХХАА-н байгууллагаас 112.8 сая төгрөгийн ариутгалын бодис, Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл төслөөс 51.7 сая төгрөгийн ариутгалын бодис, автомат тариур, 38.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 203.3 сая төгрөгийн хандив, тусламжийн орлого тайлагнасан байна.

Бусад төсөвт байгууллагаас 511.0 сая төгрөгийн шүлхий, хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцин, Төрийн өмчийн хорооны тогтоолоор 4.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл нийт 515.5 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогод хүлээн авч тайлагнасан байна.

Тайлант хугацаанд 108.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 147.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 70.6 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 1,048.5 сая төгрөгийн нөөцийн бараа, 13.7 сая төгрөгийн хангамжийн материал тооллогоор баталгаажуулан тайлагнасан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны “Журам батлах тухай” 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Мал эмнэлэг, үржлийн газар нь Шилэн дансны нэгдсэн сайтад дараах мэдээлэл оруулсан байна.

- “Төсөв” цэсний Төсөв ба гүйцэтгэл хэсэгт төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг нийт 12 удаа,
- “Төсөв” цэсний Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээ хэсэгт сар бүр гүйлгээ, түүний холбогдох тушаал шийдвэрийг нийт 12 удаа,
- “Төсөв” цэсний Батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төсөл хэсэгт холбогдох мэдээллүүдийг нийт 2 удаа,
- “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хэсэгт 2016 оны худалдан авах ажлын төлөвлөгөөг,
- “Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт” цэсний 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний мэдээлэл хэсэгт холбогдох мэдээллийг нийт 3 удаа,
- “Бусад” цэсний Тухайн байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, Аудитын тайлан дүгнэлт зэрэг мэдээллийг тус тус мэдээлсэн байна.

Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 31 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тайлант хугацаанд гарсан зардлуудаас 45.1 сая төгрөгийн томилолт, шатахууны зардлыг зохих эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй байгаа нь

санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, өглөг болон бараа үйлчилгээний орлого, зарлага зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт зардлын 55 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант жилд гарсан онцлог гүйлгээг дурдвал:

- Тайлант хугацаанд төсөвт төлөвлөгдөөгүй хонины гоц халдварт цэцэг өвчинтэй холбоотой 1,207.5 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлж зарцуулсан байна.
- Авлага дансны үлдэгдэл нийт 1,174.98 сая төгрөг байгааг ангилж үзвэл:
- Нэгдүгээрт: Хонины цэцэг өвчний вакцины 1,018.9 сая төгрөгийн үнийн дүнтэй авлага байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 12 сарын 14-ний өдрийн хуралдаанаар /хуралдааны тэмдэглэл 57/ Хонины цэцэг өвчин Монгол улсын хэмжээнд тархалттай байгааг харгалзан шийдвэрлэснээр, мөн ХХААС-ын А/68 тушаалаар Хонины цэцэг өвчний вакцин авахаар ОХУ-ын Бүх Холбоотын Мал эмнэлгийн институттай 1460/2 тоот гэрээ байгуулан 23.6 сая тун вакциныг 1,292.8 сая төгрөгөөр авахаар шилжүүлэн 2016 оны 12 сарын 27-ны өдөр 5.0 сая тун буюу 273.9 сая төгрөгийн вакцин хүлээн авч, 12 сарын 31-ээр үлдэгдэл 18.6 сая тун буюу 1,018.9 сая төгрөгийн авлагатай болсон байна.
- Хоёрдугаарт: Дээрхи шийдвэрийг үндэслэн Хонины цэцэг өвчний вакцин шингэлэгчийг Мөнхийн тун ХХК-тай 2016 оны 12-р сарын 23-ны өдөр 23600 литр 165.7 сая төгрөгийн гэрээ байгуулан шилжүүлсэн. Үүнээс 12-р сарын 26-нд 2536.2 литр 17.8 сая төгрөгийн уусгамал хүлээн авч, үлдэгдэл 147.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан байна.
- Гуравдугаарт: Ажилчдаас авах авлага 200.0 мянган төгрөг тус тус байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 1,062.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Хонины цэцэг өвчний вакцин, Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин нөөцөд авснаас өссөн байна.
- Биет хөрөнгийн дүн өссөн нь Төрийн өмчийн хорооны шийдвэрээр 4.5 сая төгрөгийн Соната-6 машин шилжүүлэн авсан, мөн Швейцарийн хөгжлийн Малын эрүүл мэнд төслөөс шуурхай албаны өрөөг тохижуулан иж бүрэн компьютер, принтер, ширээ, сандал, телевизор, канон, зэрэг 38.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авсантай холбоотой байна.

- Эмийн зардал өмнөх оноос өссөн нь Малын гоц халдварт өвчин Хонины цэцэг, Бог малын мялзан зэрэг өвчин шинээр гарсантай холбоотойгоор вакцин худалдан авах зардал өссөн байна.

Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд 163.9 сая төгрөг батлагдсан боловч гүйцэтгэлээр 213.5 сая төгрөг буюу 49.5 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 45.1 сая төгрөгийн томилолт, тээвэр шатахууны зардлыг Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас гаргасан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

Арван нэг. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал алга байна.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 45.1 сая төгрөгийн томилолт, тээвэр шатахууны зардлыг Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас гаргасан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж, 3 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Арван зургаа. Зөвлөмж

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 45.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд менежментийн захидлаар зөвлөмж өгч байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Мал эмнэлэг, үржлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1

Зардлын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Мал эмнэлэг, үржлийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Мал эмнэлэг, үржлийн газрын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 45.1 сая төгрөгийн томилолт, тээвэр шатахууны зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль, дүрэм журмыг зөрчих

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилалын дагуу төсвийг зарцуулах,

Төсвийн захирагчийн хариу

Тус газрын Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсөвт томилолт, тээвэр шатахууны зардал нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардал гэсэн эдийн засгийн ангилалд оруулж төлөвлөгдсөн учраас 2016 онд тухайн зардлаас тооцож олгосон. Мал эмнэлэг, үржлийн ажлыг хяналт, шалгалтын журмаар хөдөө ихэвчлэн ажиллаж байгаа нь хяналтын зардал гэсэн байдлаар дотоод томилолт унааны зардлыг дээрх зардалд оруулан тооцож байгаа. Цаашид энэ эдийн засгийн ангилалаар олгох саналаа хүргүүлэн батлуулж байгаа. Цаашид санхүүгийн сахилга бат, хууль журмыг сахин ажиллана.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.НАРАНЧИМЭГ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/Я.САМБУУНЯМ/

БЭЛТГЭСЭН: ШИНЖЭЭЧ

/Б.БАЯРМАА/

2017.02.20

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	49734959.40	2237346741.82
31	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31110	Төгрөг		0.00
31120	Гадаад валют		0.00
31130	Нэмэлт санхүүжилт		
31140	Касс арилжааны банк		0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах		0.00
31212	Монгол банкин дахь харилцах		0.00
31213	Арилжааны банк дахь харилцах		0.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		0.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		0.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		0.00
3122	Гадаад валют	0.00	0.00
31221	Төрийн сангийн харилцах		0.00
31222	Монгол банк дахь харилцах		0.00
31223	Арилжааны банк дахь харилцах		0.00
31224	Бусад төсөл, нөөцийн харилцах		0.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө		0.00
31500	Хадгаламж		0.00
32	БОГИНО ХУГААЦААТ ХӨРӨНГӨ	0.00	0.00
321	Үнэт цаас	0.00	0.00
32110	Төгрөг		
32120	Гадаад валют		
33	АВЛАГА	0.18	1175184939.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		200000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
33400	Зээлийн хүүгийн авлага		
33401	Дансны авлага /ТӨҮГ/		
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	0.18	1174984939.80
3351	Байгууллагаас авах авлага	0.18	1174984939.80
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
336	Зээлийн авлага	0.00	0.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	0.00	0.00
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		

33612	Хувь хүмүүст олгосон зээл		
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага		
33614	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
3362	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээл	0.00	0.00
33621	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
33622	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
33623	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
34100	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
34200	Төсөвт байгууллага		
34300	Тусгай зориулалтын сан		
34400	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		
34500	Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар		
34600	Урьдчилж гарсан зардал		
3471	Урьдчилгаа тооцоо	0.00	0.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		
34713	Цалингийн урьдчилгаа		
34714	Томилолтын урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	13137185.82	13684701.82
351	Түүхий эд материал	0.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	13137185.82	13684701.82
35410	Бичиг хэргийн материал		1438600.00
35420	Аж ахуйн материал		1860040.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	13137185.82	10386061.82
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
36	НӨӨЦИЙН БАРАА	36597773.40	1048477100.20
36100	Барааны нөөц		
36200	Үрийн нөөц		
36300	Тэжээлийн нөөц		
36400	Шатахууны нөөц		
36500	Буудайн нөөц		
36600	Бусад нөөц	36597773.40	1048477100.20
36700	Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/		
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		

36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	84834397.80	95814045.70
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
371	Урт хугацаат хадгаламж	0.00	0.00
37110	Төгрөг		
37120	Гадаад валют		
372	Үнэт цаас	0.00	0.00
37210	Төгрөг		
37220	Гадаад валют		
373	Урт хугацаат зээл	0.00	0.00
3731	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн	0.00	0.00
37311	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
37312	Хувь хүмүүст олгосон зээл		
37313	Сургалтын төрийн сангийн зээлийн		
37314	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
37315	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид		
3732	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авл	0.00	0.00
37321	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
37323	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
37324	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид		
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт-зам, гүүр		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	84834397.80	95814045.70
391	Газар		
392	Биет хөрөнгө	83905597.80	95194845.70
39201	Барилга, байгууламж, орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103536000.00	108036000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-64710000.00	-81966000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114863277.00	147059867.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95453666.86	-107932437.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60050677.97	70618677.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34380690.31	-40621262.10
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө		
39215	Хуримтлагдсан элэгдэл		
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		

393	Биет бус хөрөнгө	928800.00	619200.00
39301	Програм хангамж	523780750.00	523780750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-522851950.00	-523161550.00
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.00	0.00
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/		
39402	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/		
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/		
39404	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/		
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>134569357.20</u>	<u>2333160787.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>29948110.18</u>	<u>-0.33</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	29948110.18	-0.33
411	Богино хугацаат үнэт цаас	0.00	0.00
4111	Төгрөг	0.00	0.00
41111	Бонд		
41112	Бусад үнэт цаас		
41113	Бондын хөнгөлөлт		
4112	Гадаад валют	0.00	0.00
41121	Бонд		
41122	Бусад үнэт цаас		
41123	Бондын хөнгөлөлт		
412	Богино хугацаат зээлийн өглөг	0.00	0.00
4121	Төгрөг	0.00	0.00
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
41212	Хувь хүмүүст олгосон зээл		
41213	Сургалтын төрийн сангийн зээлийн өглөг		
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл		
41215	Монгол банк		
41216	Арилжааны банк		
41217	Санхүүгийн бусад байгууллага		
4122	Гадаад валют	0.00	0.00
41221	Гадаадын Засгийн газар		
41222	Олон улсын байгууллага		
41223	Санхүүгийн зээл		
41224	Төслийн зээл		
41225	Бусад гадаад эх үүсвэрээс		
413	Өглөг	29948110.18	-0.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2710.00	-0.33
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	29945400.18	
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		
41350	Зээлийн хүүгийн өглөг		
4136	Бусад өглөг	0.00	0.00

41361	Байгууллагад төлөх өглөг		
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/		
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		
414	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого		
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого		
41440	Бусад урьдчилж орсон орлого		
41450	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
421	Урт хугацаат үнэт цаас	0.00	0.00
4211	Төгрөг	0.00	0.00
42111	Бонд		
42112	Бусад үнэт цаас		
42113	Бондын хөнгөлөлт		
4212	Гадаад валют	0.00	0.00
42121	Бонд		
42122	Бусад үнэт цаас		
42123	Бондын хөнгөлөлт		
422	Урт хугацаат зээл	0.00	0.00
4221	Төгрөг	0.00	0.00
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
42212	Хувь хүмүүсийн зээл		
42213	Сургалтын төрийн сангийн зээлийн өглөг		
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл		
42215	Монгол банк		
42216	Арилжааны банк		
42217	Санхүүгийн бусад байгууллага		
4222	Гадаад валют	0.00	0.00
42221	Гадаадын засгийн газраас		
42222	Олон улсын санхүүгийн байгууллагаас		
42223	Санхүүгийн зээл		
42224	Төслийн зээл		
42225	Гадаадын арилжааны банк		
42226	Бусад гадаад эх үүсвэр		
42227	ОУВС-ийн зээл		
42228	Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/		
42229	Хойшлогдсон татварын өр /ТӨҮГ/		
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/		
42231	Санхүүгийн бусад байгууллага /ТӨҮГ/		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	104621247.02	2333160787.85
51	Засгийн газрын хувь оролцоо	104621247.02	2333160787.85

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	870951254.96	870951254.96
51101	Өмч: - төрийн	870951254.96	870951254.96
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	-766512872.33	1462026668.50
51210	Өмнөх үеийн үр дүн	-766512872.33	-766512872.33
51220	Тайлант үеийн үр дүн		2228539540.83
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	182864.39	182864.39
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>134569357.20</u>	<u>2333160787.52</u>

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12201961034.00	33185079900.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
110	Орлогын албан татвар	0.00	0.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.00	0.00
	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр		
110001			
110002	Үйл ажиллагааны орлого		
110003	Хөрөнгийн орлого		
110004	Хөрөнгө борлуулсны орлого		
110005	тууривах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцож олсон орлого, тэргээртэй адилтгах бусад орлого		
110006	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал		
110007	Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого		
110008	Шууд бус орлого		
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан	0.00	0.00
110101			
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.00	0.00
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		
1103	ААН-ын орлогын албан татвар	0.00	0.00
110301	ААН-ын орлогын албан татвар		
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн	0.00	0.00
110401	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.00	0.00
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл		
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		
113	Хөрөнгийн албан татвар	0.00	0.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		
113002	Бууны албан татвар		

113003	Автомобилийн болон өөрөө явагч хэрэгслийн		
113004	Малд ногдуулах албан татвар		
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.00	0.00
114001	Дотоодын барааны НӨАТ		
114002	Импортын барааны НӨАТ		
114003	НӨАТ-ын буцаан олголт		
115	Онцгой албан татвар	0.00	0.00
115001	Дотоодын архи, дарсны онцгой албан татвар		
115002	Дотоодын тамхины онцгой албан татвар		
115003	Дотоодын пивоны онцгой албан татвар		
115004	Импортын архи, дарсны онцгой албан татвар		
115005	Импортын тамхины онцгой албан татвар		
115006	Импортын пивоны онцгой албан татвар		
115007	Суудлын автомашины онцгой албан татвар		
115008	Автобензин, дизелийн түлшний онцгой албан		
116	Тусгай зориулалтын орлого	0.00	0.00
116001	Автобензин, дизелийн түлшний албан татвар		
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.00	0.00
117001	Импортын гаалийн албан татвар		
117002	Экспортын гаалийн албан татвар		
118	Бусад татвар, төлбөр, хураамж	0.00	0.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	0.00	0.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж		
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр		
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр		
118004	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		
118005	Агаарын бохирдлын төлбөр		
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал		
118007	Ус бохирдлын төлбөр		
118008	Улсын төсвийн хөрөнгөөр тогтоосон усны нөөцийн зардлын нөхөн төлбөр		
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж		
118010	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж		
118011	Бусад татвар		
1181	Газрын төлбөр	0.00	0.00
118101	Газрын төлбөр		
118102	Дуудлага худалдаа		
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.00	0.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр		
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		
1183	Бусад татвар	0.00	0.00
118301	Бусад татвар		

118302	Нийслэл хотын албан татвар		
118303	Өв, залгамжлал, бэлэглэлийн албан татвар		
118304	Нохойны албан татвар		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3057200.00	4662100.00
120	Нийтлэг татварын бус орлого	3057200.00	4662100.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос		
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос		
1E+06	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1E+06	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
120005	Түрээсийн орлого		
120006	Газрын тосны орлого		
120007	Навигацийн орлого		
120008	Монгол банкны ашиг		
120009	Бусад орлого	3057200.00	4662100.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/		
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
121	Хөрөнгийн орлого	0.00	0.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		
121002	Өмч хувьчлалын орлого		
122	Тусламжийн орлого	0.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/		
122002	Хандив тусламж /гадаад/		
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	0.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн		
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		
